Бүдүүн гэдэсний тархмал хавдар

Ч.Бадамгэрэл[1], Д.Янсанжав[1], Б.Отгонбаяр[2], Ц.Ганхүлэг[2], Л.Мөнхтуяа[2], Г.Ганцэцэг[2], У.Энхбаяр[2]

[1,2]Дорноговь Нэгдсэн эмнэлэг
[1]АШУҮИС. Дорноговь АУС
Цахим шуудан: yansanjav@mnums.edu.mn, Утас: 96641252

Түлхүүр үг:

Шулуун гэдэс
КТГ
Колоноскопи

Товч утга:

Удиртгал: Бүдүүн гэдэсний хорт хавдар гэдэг нь бүдүүн, шулуун гэдэсний дотор давхаргаас ургацаг байдлаар үүсч улмаар оношлож эмчлээгүй тохиолдолд хорт хавдарт шилждэг эмгэг юм. **Шинж тэмдэг:** Суулгах, өтгөн хатах, дутуу баасан мэт санагдах, өтгөн нарийхан хэлбэртэй, цусны судалтай, хэвлийгээр зангирч өвдөх, гэдэс дүүрэх, турах, ядрах, шалтгаан тодорхойгүй цус багадалт үүсэх. **Тохиолдол:** Үйлчлүүлэгч С.Т, 71 настай эрэгтэй. 2022 оны 09 сарын 01-нд Дорноговь аймгийн НЭ-ийн Яаралтай түргэн тусламжийн тасгаар ирж үйлчлүүлсэн. **Зовиур:** Хэвлийгээр базалж цанхайж өвдөнө, гүйлгэнэ, шулуун гэдсээр цус гарна, зүүн талын цавь орчим чулуу чихчихсэн мэт өвдөнө. **Асуумж:** 2 сарын өмнөөс гэдэс дүүрч цанхайж, унгамаар байгаа боловч хий гарахгүй. Сарын өмнөөс зүүн цавь орчмоор чулуу чихсэн мэт өвдөх зовиур нэмэгдэж улмаар өдөрт 5-6 удаа шингэн гүйлгэнэ. 2020 оноос буюу 2 жилийн өмнөөс шулуун гэдсээр цус гардаг болж тухайн үед цус тогтоох эмчилгээ хийлгэж байсан. **Оношлогоо:** Бүдүүн гэдэсний тархмал хавдар. **Ялган оношлогоо:** Diverticulitis, Ischemic colitis, Infectious colitis, Ulcerative colitis. **Дүгнэлт:** Орон нутагт тодосгогчтой КТГ шинжилгээ болон бүдүүн шулуун гэдэсний дуран хийж байгаа нь оношлогооны чадамжийг эрс нэмэгдүүлж байна.

Удиртгал: Бүдүүн гэдэсний хорт хавдар гэдэг нь бүдүүн, шулуун гэдэсний дотор давхаргаас ургацаг байдлаар үүсч улмаар оношлож эмчлээгүй тохиолдолд хорт хавдарт шилждэг эмгэг юм.

Шинж тэмдэг: Суулгах, өтгөн хатах, дутуу баасан мэт санагдах, өтгөн нарийхан хэлбэртэй, цусны судалтай, хэвлийгээр зангирч өвдөх, гэдэс дүүрэх, турах, ядрах, шалтгаан тодорхойгүй цус багадалт үүсэх.

Шалтгаан: Удамшил, бүдүүн гэдэсний үрэвсэлт өвчин, боловсруулсан махан бүтээгдэхүүний хэт их хэрэглээ, таргалалт, согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэх, ургацаг, тамхи татах

Байрлалын хувьд:

- Мухар гэдэс 10%
- Өгсөх гэдэс 15%
- Хөндлөн гэдэс 15%
- Уруудах гэдэс 5%
- S гэдэс 25%
- Шулуун гэдэс болон S гэдэс 10%
- Шулуун гэдэс 20%

Оношлогоо:

- Цусны шинжилгээ: Цус багадалт
- Өтгөний шинжилгээ: Өтгөнд цус илрүүлэх
- Бүдүүн гэдэс дурандах: Уян сигмоидоскопи дурангаар шулуун гэдэс, тахир гэдэсний зүүн хэсгийг шинжлэнэ. Хэвийн бус өөрчлөлт ажиглагдвал эдийн сорьц авч лабораторид илгээнэ
- Рентген харалт ($BaSO_4$): Дүүрэлтийн дутагдалын шинж.
- КТГ шинжилгээ: Бүдүүн гэдэсний ерөнхий байдлыг үнэлэхээс гадна салстын зузаарал /6мм-ээс дээш бол эмгэг/ болон тодосгогч бодисын тодрол байгаа эсэхийг үнэлнэ.
- РЭТ – Радио идэвхит глюкозыг тарьж хавдрын эсийг тодруулж харна[1,2,3,4,5].

Эмнэлзүйн тохиолдол: Үйлчлүүлэгч С.Т, 71 настай эрэгтэй. 2022 оны 09 сарын 01-д Дорноговь аймгийн НЭ-ийн Яаралтай түргэн тусламжийн тасгаар ирж үйлчлүүлсэн.

Зовиур: Хэвлийгээр базалж цанхайж өвдөнө, гүйлгэнэ, шулуун гэдсээр цус гарна, зүүн талын цавь орчим чулуу чихчихсэн мэт өвдөнө.

Асуумж: 2 сарын өмнөөс гэдэс дүүрч цанхайж, унгамаар байгаа боловч хий гарахгүй. Сарын өмнөөс зүүн цавь орчмоор чулуу чихсэн мэт өвдөх зовиур нэмэгдэж улмаар өдөрт 5-6 удаа шингэн гүйлгэнэ. 2020 оноос буюу 2 жилийн өмнөөс шулуун гэдсээр цус гардаг болж тухайн үед цус тогтоох эмчилгээ хийлгэж байсан.

Үзлэгт: Биеийн ерөнхий байдал дунд, ухаан санаа саруул, орчиндоо харьцаатай, арьс цэвэр чийглэг, арьсан доорх өөхөн эдийн хөгжил сул, зүрхний авиа тод хэм жигд, АД 120/90 мм муб, уушги цулцангийн цэвэр амьсгалтай, амьсгал 1 минутанд 18 удаа, судасны цохилт 75 удаа, захын цусны хүчилтөрөгчийн хангамж 94, хэвлий тайван, элэг дэлүү тэмтрэгдэхгүй, хэвлийн зүүн доогуур эмзэглэлтэй. Цөсний хүүдий мэс заслаар авагдсан. Мухар олгойн симптомууд сөрөг. Одоогоор мэс заслын цочмог шинжгүй. Захад хавангүй.

Лабораторийн шинжилгээ: (2022.09.01)


1. ЦДШ: Нянгийн гаралтай үрэвслийн шинж давамгайлсан
2. Биохими: Кератинин бага зэрэг ихэссэн

Багажийн шинжилгээ:

Хэвлийн тойм рентген харалтаар (2022.09.01): Ходоод хийтэй, хэвлийн дунд хэсгээр гэдэс гогцоо бага зэрэг хийтэй, см Арка (-), см Чаши Клойбера (-), см Серп (-)

Хэвлийн эхо (2022.09.01): Элэгний хэмжээ хэвийн, эхо ойлт бага зэрэг жигд бус ихэссэн, голомтот өөрчлөлтгүй. Цөсний хүүдий мэс заслаар авагдсан. ЦЕЦ: өргөсөөгүй. Нойр булчирхай хэмжээ хэвийн, эхо ойлт жигд ихэссэн, вирсунгийн суваг тодорсон, голомтот өөрчлөлтгүй. Дэлүү томроогүй. Бөөр АТ өргөн сийрэг, Б/бөөрөнд 1.9 см, З/бөөрөнд 1.3 см хэмжээтэй 2 тооны уйланхайтай. Давсаг шээстэй. Түрүү булчирхай хэмжээ хэвийн, голомтот өөрчлөлтгүй. Хэвлийд одоогоор сул шингэнгүй. Давсагны ард гэдэсний хана гипоэхоген өөрчлөлттэй, гэдэсний гогцоо өргөсөөгүй.

Хэвлийн тодосгогчтой КТГ шинжилгээнд (2022.09.02):



Зураг 1. Хэвлийн тодосгогч бодистой КТГ шинжилгээ


Тайлбар: Уруудах гэдэснээс шулуун гэдэсний дунд 1/3 хүртэл гэдэсний хана дагуудаа 0.7-1.1см хүртэл зузаарч жигд бус тодосгогч бодисын тодрол авсан. Эргэн тойрон өөхөн эдийн нягтрал жигд бус бага зэрэг ихэссэн.

A. Аксиаль зүслэг тодосгогчийн өмнөх фаз
B. Аксиаль зүслэг тодосгогч бодистой фаз
C. Корональ зүслэг тодосгогч бодистой фаз
D. Сагитталь зүслэг тодосгогч бодистой фаз

Impressiom:

- Diffuse wall thickening and contrast enhancement of descending colon, s colon and rectum with mild fat stranding and LAPs, need to follow up
- Tiny calcification in right liver lobe, SVIII
- Dilation of CBD
- Small simple cysts in both kidney
- Disc herniation at the L3/4, L4/5 and L5/S1 levels with bilateral neural foraminal stenosis
- Degenerative change in L-spine

Бүдүүн шулуун гэдэсний дурангийн шинжилгээ (2022.09.05):



Зураг 2. Бүдүүн шулуун гэдэсний дурангийн шинжилгээ

Тайлбар: Шулуун гэдэсний дээд амсар S гэдэс залгах хэсэгт гэдэсний хөндийрүү түрж дүүргэсэн, нэвчмэл бүтэцтэй, нэвчдэст шархлаат хэлбэрийн үүсгэвэр тодорхойлогдоно. Үүсгэврээс цааш дуран орох боломжгүй.

A. Бүдүүн шулуун гэдэсний том хэмжээний үүсгэвэр
B. Дуран S гэдэс рүү нэвтрэх боломжгүй байна.

Оношлогоо: Бүдүүн гэдэсний хавдар

Эмчилгээ: Дорноговь аймгийн НЭ-ийн Яаралтай түргэн тусламжийн тасагт хордлого тайлах, үрэвслийн эсрэг эмчилгээ хийлгэсэн. Эмчилгээний тактик үе шатаас хамаарна. Үүнд:

1. Эрт үе - мэс засал (колэктоми), туяа эмчилгээ, хими эмчилгээ
2. Хожуу үе - хөнгөвчлөх эмчилгээ

Цаашид: Үйлчлүүлэгч 13А маягтаар ХСҮТ-д илгээгдсэн бөгөөд биопсийн шинжилгээ өгч эмчилгээний тактик сонгохоор болсон.

Ялган оношлогоо:

1. Бүдүүн гэдэсний дивертикулит
2. Ишемийн колит
3. Халдварт колит
4. Шархлаат колит

Хэлцэмж: 2020 оны байдлаар ДЭМБ, Хавдар судлалын олон улсын агентлагийн гаргасан тайланд бүдүүн гэдэсний хорт хавдар нь дэлхий дахинд түгээмэл тохиолддог хавдруудын 3-р байранд ордог ба хүйсийн хувьд эрэгтэйчүүдэд – 2, эмэгтэйчүүдэд 3-р байранд ордог байна. Мөн хорт хавдрын шалтгаант нас баралтаар дэлхийд 4-р байранд ордог[6].

Манай улсын хувьд бүдүүн шулуун гэдэсний хорт хавдар нь одоогоор тохиолдлоороо эрэгтэйчүүдийн дунд – 5, эмэгтэйчүүдийн дунд 7-р байранд орж байна.

Статистикаас харвал 2004 онд Монгол улсад бүдүүн шулуун гэдэсний хорт хавдрын шинэ тохиолдол жилд 76 бүртгэгдэж байсан бол 15 жилийн дараа буюу 2019 онд энэ тоо 260 хүртэл өссөн байна[7]. Харин манай орон нутгийн хувьд 2021 оны байдлаар нийт 469 хорт хавдар бүртгэгдсэнээс 12 (2.5%) нь бүдүүн шулуун гэдэсний хавдар гэж оношлогдсон байна. Зөвхөн 2021 оны статистикаас харахад хорт хавдрын 112 тохиолдол бүртгэгдсэнээс 3.6% (n=4)-ийг бүдүүн гэдэсний хавдар эзэлж нийт тохиолдлын тоогоор 7-р байрт орж байна. Уг 4 тохиолдол нь хүйсийн хувьд бүгд эмэгтэй байсан бөгөөд байршил нь бүдүүн гэдэсний өгсөх хэсэгт – 1, уруудах хэсэгт – 2, байрлал тодорхойгүй – 1 оношлогдсон байна[8].

Бидний энэ тохиолдлын хувьд бүдүүн гэдэсний нийт уртын 2/3 буюу дэлүүний булангаас эхлээд шулуун гэдэсний дунд 1/3 хүртэл үргэлжилсэн том хэмжээний эмнэлзүйд төдийлөн ховор тохиолддог хэлбэр юм. Улс орон хөгжиж, нийгэм эдийн засгийн байдал сайжрах, амьдралын хэв маяг илүү хотжих тусам бүдүүн шулуун гэдэсний хорт хавдрын тохиолдол хурдтай өсөн нэмэгддэг ба энэ үзэгдэл ганцхан манай оронд тохиолдож байгаа хэрэг биш юм. 20-р зууны дунд хэсэгт БНСУ, Япон зэрэг азийн өндөр хөгжилтэй орнуудад энэ өвчин тохиолдол бага байсан ч улс орон хөгжиж насжилт уртсахын хэрээр тохиолдол тоо нэмэгдэх болсон. Хэдийгээр одоо Монгол улсад элэг, ходоодны хорт хавдар хамгийн элбэг тохиолддог хорт хавдар байгаа ч магадгүй 20 жилийн дараа бүдүүн гэдэсний хорт хавдар тэргүүлэх шалтгаан болох магадлалтай[7].

Дүгнэлт: Орон нутагт тодосгогчтой КТ шинжилгээ болон бүдүүн шулуун гэдэсний дуран хийж байгаа нь оношлогооны чадамжийг эрс нэмэгдүүлж байна.

Ном зүй:

1. *Micheal P. Federe: Diagnostic imaging abdomen. RC944.D526 2004. 1-5, 45-54*
2. *T.B Moeller and E. Reif: Sectional anatomy, Computed tomography and Magnetic Resonance imaging. Thieme New Yor, 333 Seventh Avenue. New York ,N.Y. 10001, USA 2007. 101-106*
3. *Д.Гончигсүрэн, Д.Мөнхбаатар. Радиологийн үндэс. Улаанбаатар 2015. 102-106*
4. *Bar-Shalom R et al: Clinical performance of PET/CT in evaluation of cancer: additional value for diagnostic imaging and patient management. J Nucl Med 44(8):1200-9 2003*
5. *Cohade Cet al: Direct comparison of (18)F-FDG PET and PET/CT in patient with colorectal carcinoma. J Nucl Med. 44(11):1797-803,2003*
6. *https://www.wcrf.org/cancer-trends/colorectal-cancer-statistics/#:~:text=Colorectal%20(also%20known%20as%20bowel,of%20colorectal%20cancer%20in%202020.*
7. *http://itoim.mn/article/wKtkT/26357*
8. *Дорноговь аймгийн Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааны үндсэн тайлан 2021*

Diffusely infiltrative colon cancer

Badamgerel Ch[1], Yansanjav D[1], Otgonbauyar B[2], Gankhuleg Ts[2], Munkhtuya L[2], Gantsetseg G[2], Enkhbayar U[2]

[1,2]Dornogobi Hospital
[1]Dornogobi Medical School, MNUMS
E-mail: yansanjav@mnums.edu.mn, Утас: 96641252

Background: Colon cancer is a disease that develops in the lining of the colon and rectum and it turns into cancer unless diagnosed and treated early.
Symptoms: diarrhea, constipation, feeling like incomplete bowel movement, slimy stools, bloody stools, abdominal cramping, bloating, weight loss, fatigue, and occur unexplained anemia.
Case: Patient T. S, is a 71-year-old male. He received health care service on 01 September 2022 by the Emergency Care Department.
Present complaint: abdominal cramping and bloating, diarrhea, rectal bleeding, pain as if a stone had been stuffed around the left groin. ,
Question: For the past 2 months, although the patient has been feeling trapped in gas, and bloating, he can't have excess gas in his stomach. Starting a month ago, he has been having fluid diarrhea 5-6 times a day because the pain which was as if a stone had been stuffed in the left groin increased. Since 2020 or starting 2 years ago, he has been receiving hemostasis treatment due to rectal bleeding.
Diagnosis: colon cancer
Differential diagnosis: Diverticulitis, Ischemic colitis, Infectious colitis, Ulcerative colitis
Conclusion: CT scan and colonoscopy diagnoses being run in local hospitals are significantly increasing diagnosis capacity.

Keywords: Rectum, Computed tomography, Colonoscopy